



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 116

Дархан

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2015 оны Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай" 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Дархан дахин төлөвлөлт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д даалгасугай.

ДАРГА  Г.ЭРДЭНЭБАТ

“ДАРХАН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ” ОНӨААТҮГ -ЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилт нь “Дархан дахин төлөвлөлт” ОНӨААТҮГ (Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой Үйлдвэрийн газар)-ын эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлага тогтоох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Дархан дахин төлөвлөлт” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар товчилсон нэр нь “ДДТ” ОНӨААТҮГ байх ба өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, бие даасан тайлан тэнцэлтэй, үндсэн зорилго нь орлогоороо зарлагаа нөхөж ашигтай ажиллах бөгөөд өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1.3 Үйлдвэрийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Татварын хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот, байгуулалтын тухай хууль, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Орон сууцны тухай хууль, Компаний тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Агаарын бохирдлын бууруулах Үндэсний хөтөлбөр болон бусад холбогдох шинээр гарсан хууль тоогтоомжид нийцүүлэн энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагааг явуулна.

1.4 Үйлдвэрийн газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд :

- 1.4.1 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, төлөвлөх, барилгажуулах,
- 1.4.2 Үндсэн тосгон болон туслах тосгоныг дахин төлөвлөх, барилгажуулах,
- 1.4.3 Түрээсийн орон сууцны харилцааг зохицуулах,
- 1.4.4 Орон сууцны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах,
- 1.4.5 Агаар, орчины бохирдлыг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах,

1.5 Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч өмчлөгч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөллийг хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байна.

ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БЭЛЭГДЭЛ, ТЭМДЭГ, ХЭВЛЭМЭЛ ХУУДАС

2.1 Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны онцлогыг илтгэсэн бэлэгдэлтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.2 Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

2.3 Тэмдгийг үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын итгэмжлэгдсэн этгээд хариуцна.

2.4 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага бэлэгдэл, тэмдгийн загварыг баталж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх бөгөөд хэрэглэх эрхийг эдлэнэ.

ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

3.1 Үйлдвэрийн газрын бүтэц орон тооны дээд хязгаарыг Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга тогтооно.

3.2 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлөх ба бусад ажилтныг газрын газрын гүйцэтгэх удирдлага тус тус томилж, чөлөөлнө.

3.3 Үйлдвэрийн газрын дотоод зохион байгуулалтын хувьд газрын гүйцэтгэх удирдлага, Ерөнхий инженер, хэлтэс, албад, мэргэжилтэн, ажилтнуудаас бүрдэнэ.

3.4 Газрын гүйцэтгэх удирдлага гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлжуулж, гэрээ байгуулж, хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

3.5 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, төлөвлөх, барилгажуулах Үүнд :

а. Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах

б. Ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган, шинээр орон сууцжуулах

в. Сумдын гэр хорооллын газрыг зохих шатны байгууллагын зөвшөөрлын үндсэн дээр дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах

3.5.1 Хот, суурин газрыг нийгэм эдийн засаг, экологи байгаль орчин, соёл, боловсролын тогтвортой тэнцвэрийг хангасан, суурьшлын бүс болоход чиглэсэн, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

3.5.2 Гэр хорооллын газарт шинээр хийгдсэн инженерийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулах айл, өрхийг хамруулах хаус хороолол байгуулах

3.5.3 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулахтай холбоотой, тохижилт үйлчилгээний стандарт, дүрэм, журам боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангуулах

3.5.4 Гэр хорооллын хөгжлийн асуудлаар, аливаа санал, санаачлагуудыг хөхүүлэн дэмжиж, Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны ойрын болон хэтийн төлөвлөгөөг үе шаттайгаар зохион байгуулах хэрэгжүүлэх

3.5.5 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулахтай холбоотой хамтран ажиллах байгууллага иргэдтэй, бүх талаар харилцан үр дүнтэй хамтран ажиллах

3.5.6 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах талаар зургийн даалгавар, техникийн тодорхойлолтуудыг боловсруулж, аймгийн Ерөнхий архитектороор хянуулж аймгийн Засаг даргаар батлуулан мөрдөн ажиллах

3.5.7 Зураг төсөл захиалах түүнд хяналт тавих, холбогдох байгууллагын зөвшөөрөл авах, төрийн байгууллагуудын зураг төсөл захиалгаар гүйцэтгэх

3.5.8 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн ажлын даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, захиалагчийн хяналтыг тавьж гүйцэтгэлийг хангуулах, холбогдох арга хэмжээний саналыг бусад газруудад уламжлах

3.5.9 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, төлөвлөлттэй холбоотой эрх зүйн харилцааны бичиг баримтуудыг судлах, тэдгээрийг иргэдэд ойлгуулан сурталчлах, гарын авлага тараах материалууд хэвлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет цахим системээр, өөрийн байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчлах

3.5.10 Гэр хороолол, Үндсэн тосгон болон туслах тосгоны дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх, айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, түр оршин суух түрээсийн байранд оруулах, ажлыг гэрээний үндсэн дээр цаг хугацаанд нь зохион байгуулах

3.6 Үндсэн тосгон болон туслах тосгоныг дахин төлөвлөх, барилгажуулах

3.6.1 Хуучин Дарханы Үндсэн тосгон болон туслах тосгоны газрыг дахин зохион байгуулах, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлэх

3.6.2 Брак байруудыг буулган, дахин төлөвлөн барилгажуулах ажлыг зохион байгуулах

3.7 Түрээсийн орон сууцны харилцааг зохицуулах

3.7.1 Орон сууц худалдан авах боломжгүй, түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийг хамруулах асуудлыг "Дархан дахин төлөвлөлт" ОНӨААТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна;

3.7.2 Төрийн болон Орон нутгийн өмчийн оролцоотой түрээсийн орон сууцны ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх, иргэдийн түр оршин суух байрны гэрээг байгуулах түүнд хяналт тавих, түрээслэх, орлогыг төсөвт төвлөрүүлэх

3.7.3 Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, хөрөнгийг эргэлтэд оруулах барилгажуулах

3.7.3.1 Орон сууцны барилга, хотхон, хороолол барих хөрөнгө оруулагчдад газар, дэд бүтцийн бусад асуудлыг хөнгөлөлттэй нөхцөлөөр шийдвэрлэн өгч, баригдсан орон сууцны нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх арга хэмжээ авах;

3.7.3.2 Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс жил бүр тодорхой хөрөнгө гаргаж, түрээсийн орон сууцны барилга захиалж бариулах, эсхүл шинээр баригдаж, ашиглалтад орсон боловч зах зээл дээр борлогдоогүй орон сууцнаас худалдан авах замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх.

3.7.4 Түрээсийн орон сууцыг дамжуулан түрээслэх, түрээсийн орон сууцыг өмчлүүлэхтэй холбоотой журамд зааснаас өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалахыг хориглоно;

3.8. Орон сууцны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах

3.8.1 Иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх, орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэх

3.8.2 Инженерийн хангамжийн шугам сүлжээ, эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх, шинээр барих, төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах, түрээсийн болон халамжийн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх

3.9 Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах

3.9.1 Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах

3.9.2 Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах;

3.9.3 Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах

3.9.4 Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, санхүүжилтийг тодорхой болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох

3.9.5 Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь аймгийн Засаг даргын өмнө хүлээсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах ба дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.2 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх

4.3 Үйлдвэрийн газрыг төлөөлж гэрээ, хэлцэл байгуулах

4.4 Үйлдвэрийн газрын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах

4.5 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заагдсан татвар хураамжийг төлсний дараах цэвэр ашгийг аймгийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр зохих журмын дагуу захиран зарцуулах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

4.6 Үйлдвэрийн газрын ажилтнуудыг томилж, чөлөөлөх, гэрээ байгуулах түүнийг дүгнэх Үйлдвэрийн газрын байнгын ажилтнууд ажлын байрны тодорхойлолттой байх ба ажлын ачаалал, тусгай шаардлагуудыг харгалзан мэргэжлийн хүмүүсийг тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхээр гэрээт ажилтан ажиллуулж болно.

4.7 Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч, сангийн хэмжээнд ажилтнуудын цалинг тогтоох

4.8 Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлүүлэн, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистик тайлан мэдээ гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх,

4.9 Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үүний тулд үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх заавар, журам гаргаж биелэлтийг хангуулах

4.10 Үйлдвэрийн газрын материалаг баазыг бэхжүүлэх

4.11 Дахин төлөвлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор иргэдэд мэдээллээр бүрэн хангах, харьяалах нутаг дэвсгэрийн иргэдээс /хяналтын хороо/ тухай бүр байгуулах, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах асуудлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, төсөлд оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах

ТАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТӨСӨВ, САНХҮҮ

5.1 Үйлдвэрийн газрын санхүү нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.1.1 Орон нутгийн төсвөөс олгосон дэмжлэг

5.1.2 Өөрийн орлого

5.1.3 Бусад эх үүсвэр

5.2 Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох, бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр

D:/hural documents/togtool

гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулж түүнийг өмчлөгч байгууллагад хагас бүтэн жилээр тайлагнах

5.3 Байгууллагын үйл ажиллагаанаас олсон орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлнэ.

5.4 Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг газрын дарга нягтлан бодогч хариуцна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү дүрмийг зөрчсөн буруутай этгээд нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ

7.1 Энэхүү дүрэмд заасан зорилт чиг үүрэг бүрэн хангагдсан гэж үзэж, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагагүй болсон тохиолдолд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд аймгийн Засаг дарга санал оруулснаар татан буулгах эсэх талаар шийдвэр гаргуулна.

7.2 Үйлдвэрийн газрыг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу төлсний дараа үндсэн хөрөнгийг үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

7.3 Татан буугдсан тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс тус ажлыг эрхэлнэ.

НАЙМ. БУСАД

8.1 Энэхүү дүрмийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр мөрдөх болно.

8.2 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулахдаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж, нэмэлт өөрчлөлт оруулан, Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

8.3 Дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт дүрмийн салшгүй хэсэг байна.

__oOo__